

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ: ЭХ ДЭЛХИЙ, УРГАМАЛ АМЬТАН, УУЛ УС, БАЙГАЛЬ ОРЧНОО ХАЙРЛАН ХАМГААЛАХ ЯВДЛЫГ БҮХ НИЙТИЙН ҮЙЛС БОЛГОН ӨРНҮҮЛНЭ



Монгол Улсын зургаа дахь Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн тангараг өргөх ёслол Баасан гарагт Төрийн ордны Их танхимд боллоо. Монгол Улсын Ерөнхийлөгч нээлтийн ёслолын үеэр ард иргэдэд хандан үг хэлэхдээ “Эх дэлхий, ургамал амьтан, уул ус, байгаль орчноо хайрлан хамгаалах явдлыг бүх нийтийн үйлс болгон өрнүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, хөрс, ус, агаарын бохирдол, уул уурхай үйлдвэржилтээс бий болсон байгалийн доройтлыг нөхөн сэргээх зэрэг экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах идэвх санаачилгыг төрийн бодлогын цөм, түмэн олны үйл хэрэг болгох нь зүйтэй хэмээн үзнэ” гэсэн юм. Мөн тэрбээр “Сүүлийн жилүүдэд та бидний эхлүүлсэн газрын тосны үйлдвэр, гангийн үйлдвэр, байгалийн хийн хоолой, цэвэрлэх байгууламж, саарал усны үйлдвэр, сайжруулсан түлшний үйлдвэр, шинэ нисэх онгоцны буудал, эрчим хүч, дэд бүтцийн ... зэрэг томоохон төсөл хөтөлбөрүүдээ улам эрчимжүүлж, үр дүнг нь үзэх зайлшгүй шаардлагатай байна. Үүний зэрэгцээ хүнд ба хөнгөн үйлдвэрүүдийг барьж байгуулан, алт, зэс, төмөр, нүүрс болон байгалийн бусад баялаг, малын гаралтай түүхий эдээ эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулдаг, аж үйлдвэржсэн экспортлогч орон болох зорилтыг бодит ажил хэрэг болгохын төлөө УИХ, Засгийн газрыг хуулийн хүрээнд дэмжин, хамтран ажиллах болно” гэлээ.

Эх сурвалж: БОАЖЯ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар

ТУУЛ ГОЛЫН ЭХЭНД МИНЖ НУТАГШУУЛЛАА



Туул голын усны урсцыг байгалийн аргаар нэмэгдүүлэх замаар экосистемийн доройтлыг бууруулж, голын сав газрын экологийн нөхцөлийг сайжруулахаар 2012 онд ОХУ болон ХБНГУ-аас 17 бүлийн нийт 34 бодгаль Евразийн минжийг авчран өсгөж байна. Минж үржүүлэн нутагшуулах ажлын хүрээнд 2012-2020 он хүртэл нийт 57 бодгалийг Туул голын эх түүний цутгал болох Заан, Тэрэлж голуудад нутагшуулаад байгаа билээ. Энэ жилийн хувьд “Минж үржүүлэх, нутагшуулах төвд” төслийн хугацаанд анх удаа 1 бодгаль минжнээс 5 ихэр дүдэр төллөсөн онцлогтой байсан

бөгөөд нас биед хүрсэн 3 бүлийн 6 бодгаль минжийг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа болон МУИС-ийн эрдэмтэн, судлаачидтай хамтран Төв аймгийн Эрдэнэ сумын 2 дугаар багийн нутагт минжийн шүтэж амьдардаг орчин бүхий хэсэгт аядуу зөөлөн суллан тавих аргыг сонгож усны төвшин, урсгалын хурд болон эргийн нөхцөлийг харгалзан ус боох далан хийж, татмын нугыг намагжуулах цүнхээл үүсгэх зэргээр дэмжлэг үзүүлж тавьжээ. Цаашид Туул голын эхэнд 100-150 бүл байгалийн популяц үүсгэх зорилго тавин ажиллаж байгаа аж. Ингэснээр байгалийн болон хүний сөрөг нөлөөлөлд бага өртөх улмаар өөрөө өсч үржих боломж бүрдэх юм байна.

сурвалж: Нийслэлийн Байгаль орчны газар

Д.ИХБАЯР: УХААЛАГ СИСТЕМЭЭР УСНЫ ХЭРЭГЛЭЭГЭЭ ХЯНАНА

Нийслэлийн орон сууцны зарим өрх усны тоолуургүй буюу хэрэглээг задгай тарифаар тооцон төлбөр бодогддог. Эдгээр өрхүүд сар бүр тоолууртай айлуудаас 20000 орчим төгрөгөөр илүү төлбөр төлдөг төдийгүй хэрэглээгээ хянах боломжгүй байгаа юм. Иймд “Улаанбаатар хотын орон сууцны болон саарал усны хэрэглээг хянах, хэмнэх инновац технологийн шийдэл” төслийг хэрэгжүүлэх гэж байна. Энэ талаар Нийслэлийн инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, НИТХ-ын төлөөлөгч Д.Ихбаяр “...Усны тоолуургүй айлуудыг тоолууржуулах, ингэхдээ ухаалаг, оновчтой технологийн шийдлийг ашиглах боломжтой бөгөөд богино долгионы “Лоро ван” системийг ашиглан ухаалаг тоолуурыг хэрэглээнд нэвтрүүлэх юм. Ингэснээр хяналтын байцаагч нар айл бүрээр явах шаардлагагүй болж, усны тоолуурын заалтыг автоматаар авна. Алсын зайнаас тоолуурын хаалтыг хааж, нээн, хэрэглээгээ хянах боломжтой юм. Мөн холбогдох байгууллагууд хяналт, дүн шинжилгээ хийх нэгдсэн систем бүхий мэдээллийн бааз үүснэ. Харин иргэд, хэрэглэгчдийн хувьд усны зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг гар утасны аппликэйшн ашиглан авах боломжтой төдийгүй ус алдах, техникийн эрсдэлээс сэргийлнэ. Түүнчлэн ухаалаг тоолуурыг ашигласнаар сар бүр усны зардлынхаа 30-40 хувийг хэмнэх бөгөөд хэрэглээгээ хянаж, усны зөв зохистой хэрэглээг бий болгох боломжтой юм...” гэж яриу. Ярилцлагын дэлгэрэнгүйг эх сурвалжаас унших боломжтой.

Эх сурвалж: Ulaanbaatar.mn

ТОВЧХОН

–УСУГ Дусалхүү подкастынхаа ээлжит дугаарыг [“Бага оврын цэвэрлэх байгууламж болон цэвэршүүлсэн усаа эргүүлэн ашиглах заавар”](#) сэдвээр хүргэж байна. Подкастын зочноор УСУГ-ын ХҮА-ны Бохирдуулагч үйлдвэрийн хяналтын инженер Т. Билгүүн оролцож дээрх сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ [Эх сурвалж: УСУГ](#)

–Хэрлэн голын сав газрын захиргаа, Онон, Улз голын сав газрын захиргаа, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаанаас Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр Хэнтий аймгийн сумдын БОХУБ, Татварын байцаагч, байгаль хамгаалагч, ААНБ-н төлөөллүүдэд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн сургалтыг зохион байгуулжээ. [Эх сурвалж: Хэрлэн голын сав газрын захиргаа](#)

–БОАЖЯам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, 2030 усны нөөцийн бүлэг хамтран 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан Усны данс (Water Accounting)-ыг танилцуулах цахим сургалтад бүх сав газрын захиргаад хамрагджээ. [Эх сурвалж: Хэрлэн голын сав газрын захиргаа](#)